



1639 УЛААНБААТАР 2019

“ХОТ БАЙГУУЛАЛТЫН ТҮҮХЭН ҮЙЛ ЯВЦ:
ӨНГӨРСӨН, ОДОО, ИРЭЭДҮЙ”
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ

Ултгэлийн эмхэтгэл



БОГДЫН ХҮРЭЭНИЙ СҮМ ДУГАНУУД



Нэр: Телеки Кристина

*Байгууллага: Монгол ба Төв Ази судлалын тэнхим,
Монгол Судлалын төв*

Албан тушаал: Эрдэм шинжилгээний ажилтан

Зэрэг цол: Доктор /Ph.D./

Монгол улсын өнөөгийн Улаанбаатар нийслэл хот анх 1639 онд сууриа тавьснаас хойш 28 удаа нүүж 1855 онд энэ хөндийд суурьшсан түүхтэй. 1706 он хүртэл Өргөө хэмээх нэрээрээ нэрлэгдэж байлаа. Харин 1706-1778 он хүртэл Их хүрээ, 1778-1911 он хүртэл Да хүрээ зарим үед Хүрээ гэж дууддаг байжээ.¹ 1911-1924 он хүртэл Нийслэл хүрээ, 1924 онд одоогийн нэрээр нэрлэгдэх болсон байна. Ард түмний дунд нийслэл хотыг Ардын хувьсгалаас өмнө их олон янзаар нэрлэж байжээ. Жишээ нь: Богдын хүрээ, Хутагтын хүрээ, Хүрээ, Номын их хүрээ гэх мэт. Гадаадын судлаачдын зохиол бүтээлд тэр дундаа европын орнуудад Урга (Өргөө) нэрээр нэрлэсэн байдаг. XIX дүгээр зуунаас эхлэн Монгол орны гол засаг захиргаа, эдийн засаг, худалдаа арилжаа, шашны томоохон төв болон хөгжсөн. Нийслэл хүрээ нь 30 аймаг, 10 дацантай,² түмэн гэлэнгийн хайлан хурдаг хамгийн том хүрээ байлаа. Хүрээ нь их хэлмэгдүүлэлт болох хүртэл 100 шахам сүм дугантай байсан. Энэ өгүүлэлд хороонуудад байсан сүм дугануудын нэр байршил товчхон танилцуулна.³

Богдын хүрээний сүм дуганууд

Богдын хүрээ XX зууны эхээр доорх хэсгүүдээс бүрдсэн:

Лам нарын суудаг байсан Зүүн хүрээ (1), болон Гандан (2); Харчуудын хороонууд (3): Баруун өмнөд болон Зүүн өмнөд хороо, Зүүн харчууд ба Их шавь; Чойжин ламын сүм (4); Богд хааны орд харш Туул голын эрэг дэхь (5); Орос консулын дэнж (6); Хятад худалдааны хот буюу Маймаачэн (7); Хятад дамнуурчингуудын хэсэг: Зүүн болон Баруун дамнуурчин (8); Хотын захын газрууд (9).

¹ http://www.archives.gov.mn/index.php?option=com_content&task=view&id=567&Itemid=302&lang=mn

² Чойрын гурван дацан (Дашчоймбэл, Гунгаачойлин, Идгаачойнзинлин) ба Дэчингалав буюу Дүйнхор, Манба, Зурхай, Жуд, Ламрим, Бадмаёго, 1924 онд баригдсан Агва дацангуудаас гадна Майдар, Жанрайсэг, Чойжин ламын сүм, Дашсамданлин дуганууд ч дацан гэж нэртэй байсан.

³ 2005-2006 онд Унгар улсын монгол судлаач Majer Zsuzsa, Teleki Krisztina нарын хамтарсан судалгааны зорилго нь Улаанбаатарын хуучин ба орчин үеийн сүм дугануудын байсан газруудыг тогтоох, өнөө үед ямар байгаа талаар тэмдэглэх, судлах явдал байсан. Дэлгэрэнгүй мэдээллийг <http://www.mongoliantemples.net/en/>, Teleki 2012, Телеки 2010 зохиолуудаас үзнэ уу.



1. Зүүн хүрээ

Зүүн хүрээний (одоогийн Сүхбаатар дүүрэг. Зүүн хүрээний төв хэсэг нь Хүүхдийн урлан бүтээх төв ба МУИС-ийн IV дүгээр байрын орчим) төв хэсэгт Өндөр гэгээн Занабазарын санаачилсан хэлбэрийн дагуу баригдсан Рэбогэжай Ганданшаддүвлин буюу Батцагаан цогчин дуган болон Богдын Шар ордон байжээ. Мөн 3 дацан болон бусад сүм дугануудыг тойроод 30 аймаг байжээ. 30 аймаг нийт 30 аймгийн дугантай байв. Зүүн хүрээний дуганууд нь:

Шар ордон дотор:⁴

Дэчингалав (тө. bde chen bskal-pa) буюу Дүйнхор дацан (тө. dus 'khor)

- Ригсүмгомбын сүм (тө. rigs gsum mgon-po)
- Доржповран (тө. rdo-rje pho-brang)
- Дарь эхийн сүм
- Очирдарийн сүм (тө. rdo-rje 'dzin-pa)
- Түнлхагийн хурал (тө. 'khrungs lha)
- Намсрайн хурал (тө. rnam thos sras)
- Жанцантомбо (тө. rgyal mtshan mthon po), г.м.гэр тугдамуудтай.

Цогчин дуганы эргэн тойрон

- Батцагаан цогчин дуган, Рэбогэжай Ганданшаддүвлин (тө. ri bo dge rgyas dga`ldan bshad sgrub gling)
- Майдарын сүм
- Манба дацан (тө. sman-pa grwa-tshang)
- Ноён шүтээний сүм
- Ганжуурын дуган (тө. bka'-'gyur-gyi 'du-khang)
- Гүрмийн дуган (тө. sku-rim-gyi 'du-khang)
- Солгийн дуган
- Хойд өргөө⁵
- Зурхайн дацан (тө. rtsis-pa grwa-tshang)
- Жүд дацан (тө. rgyud-kyi grwa-tshang)
- Дуу тасрахгүй хурал
- Автай сайн ханы өргөө буюу Баруун өргөө

30 аймгийн дуганууд

Шүтээний аймаг, Дондовлингийн аймаг (тө. don grubgling), Жадарын аймаг (тө. khye'i rdo rje), Тойсамлин (тө. thos bsam gling), Дүйнхор

⁴ Пүрэв 2004, 9-10.

⁵ Пүрэв 2004, 19.



(тө. *dus 'khor*), Сэцэн тойны, Андуу нарын (тө. *a-mdo*), Дашдандарлин (тө. *bkra-shis bstan dar gling*), Махамаяа (с. *Mahāmāyā*), Жас (тө. *spyi gsog*) буюу Пунцогтэгчэнлин (тө. *phun tshogs theg chen gling*), Номч, Сангай, Зоогой, Дугар (тө. *gdugs dkar*), Чойнхорлин (тө. *chos 'khor gling*), Мэргэн хамбын, Бизъяа (с. *Vijayā*), Хүүхэн ноёны, Дархан эмчийн, Эрхэм тойны, Эх дагинын, Вангайн, Эрдэнэ хувилгааны, Баргын аймаг, Намдоллин буюу Дашиллин (тө. *rnam grol gling*, *bkra-shis gling*), Бандид (с. *paṇḍita*), Сүнгийн аймаг (тө. *gsung*), Лам нарын аймаг, Мэргэн номон ханы аймаг, Өрлүүдийн аймаг. Мөн Эх дагинын аймаг Өндөр гэгээний сүм хэмээх дугантай ч байсан.

2. Гандан

Гандан (тө. *dga'-ldan*) дэнж нь суралцах, сахил санваараа сахидаг ариун газар байлаа. Гандангийн дугануудыг тойроод 30 аймаг байжээ. Аймгийн дуганууд байгаагүй. Дуганууд нь:

Урд хэсэг

1. Гандантэгчэнлин дуган (тө. *dga'-ldan theg chen gling*)
2. Тавдугаар богдын шарил сүм
3. Долоодугаар богдын шарил сүм
4. Наймдугаар богдын шарил сүм
5. Дидинповран (тө. *bde stong pho-brang*)

Хойд хэсэг

1. Дашчоймбэл дацан (тө. *bkra -shis chos 'phel*)
2. Гунгаачойлин дацан (тө. *kun dga' chos gling*)
3. Идгаачойнзинлин дацан (тө. *yid dga' chos 'dzin gling*)
4. Бадма ёга дацан (тө. *pad-ma yo-ga*)
5. Ламрим дацан (тө. *lam rim*)
6. Мигжид жанрайсэгийн дуган (тө. *mig byed spyan ras gzigs*)

Ганданийн ар талд

1. Жаранхашарын суварга (тө. *bya-rung kha-shor*) буюу Цагаан суврагын хурал

Хороо

Дүгэрсүрэнгийн бичснээр⁶ хорооны харчууд бол Баруун өмнөд хороо (Улсын их дэлгүүрийн хавьцаа) болон Зүүн өмнөд хороонд суудаг (одоогийн Арслантай гүүрнээс баруун ба зүүн өмнөд хэсэг). Зүүн хүрэнээс зүүн зүгт Зүүн харчууд ба Их шавьд амьдардаг. Хороонд хөдөөнөөс хааяа ирдэг тайж ноёдын сууц ч байдаг байжээ. Хорооны сүм дугануудын ихэнхи нь улааны ёсны, зодын (тө. *gcod*) хурлууд

⁶ Дүгэрсүрэн 1999, 52.



байсан. Мөн шарын шашны сүм хийдүүд хороонд ч байсан. Зүүн өмнөд хороонд Амбан ханы хороо гэдэг монгол, манж амбаны хороо байсан. Сүүлчийн манж амбан 1911 он хүртэл Хүрээнд суусан Сан-дуо, гэрийг нь Зүүн Сэлбийн эрэгт барьснаар Манж амбаны хурлын дуган үүсчээ.⁷ Зүүн харчууд (одоогийн Сэлбийн зүүн талд орших Сансар хорооллын хойт тал) Зүүн хүрээний зүүн хойт хэсэгт байв. Эдгээрээс зүүн өмнө (одоогийн Сэлбийн зүүн талд орших Сансар хорооллын өмнөд тал) Богдын их шавиас ирсэн харчууд суух бөгөөд тусдаа Их шавийн хурал хурдаг байсан. Их шавийн өмнө хэсэгт ХХ зууны эхээр Америкийн пүүсүүд байснаас Американ дэнж хэмээн нэрлэх болжээ. Хороонд байсан дуганууд нь:

Баруун өмнөд хороо

- Нартад Дагинын хурал (Дамдин ламын хурал, Нартад дагнангийн хурал, зодын хурал)
- Төвдийн хурал (Унзай ламын хурал)
- Дарь эхийн хурал (тө. sgröl-ma)
- Доржзодвын хурал (тө. rdo-rje gcod-pa)
- Тантонжалбын хурал (зодын хурал, тө. thang-stong rgyal-po)
- Жагармоломын хурал (Дэчинчойлин тавши сүнбрэллин, зодын хурал, тө. bde-chen chos-dbyings thabs-shes zung-'brel gling)

Зүүн өмнөд хороо

- Манж амбаны хурлын дуган

Их шавь

- Их шавийн харчуудын хурал буюу Сайхан Гомбын сүм (тө. mgon-po)

4. Чойжин Ламын сүмийн эргэн тойрон

Зүүн хүрээнээс өмнөд 1904-1908 оны хооронд барьсан Чойжин ламын сүм Лувсанхайдавын хурлын газар байлаа. Чойжин ламын сүмийн зүүн талд нь Ёнзон хамбын сүм (тө. yongs-'dzin mkhan-po) бол VIII богд ба Лувсанхайдавын жавтгүй ба ёнзон байсан Лувсанхаймчог хамба номон ханы сүм байжээ. Чойжин ламын сүмийн хойт талд Ойдовын хурал ба Дагва зодчийн хурал байсан.⁸ Агва дацан нь 1924 онд баригдсан.

- Чойжин ламын сүм (Өршөөлийг хөгжүүлэгч сүм, Занхан, Зэпэллин сүм, Номыг тэтгэгч, Шашин сахигчийн ордон, тө. chos-skyong bla-ma, brtse-'phel gling, gtsang-khang).

Ёнзон хамбын сүм (тө. yongs-'dzin mkhan-po)

Ойдовын хурал

⁷ Пүрэв 2004, 37.

⁸ Улааны ёсны хурал байсан бололтой. Яг байсан газрын талаар зөрүүтэй баримтууд байна



- Дагва зодчийн хурал/сүм (зодын хурал)
- Агва дацан (Аху дацан, Аваг дацан, тө. sngags-pa grwa-tshang)

5. Туулын эрэг орчим

Өндөгийн сүргийн нутаг гэж байсан газарт⁹ Богдуудын төрөл садангуудын адуу, мал сүрэг байсан газрын дунд Богд хааны ногоон сүм, Богд хааны өвлийн ордон, амьтны хүрээлэн (Норовлин/Норовлинхай, тө. nor bu gling ka) байжээ. Эдгээр ордонуудад цөөн тооны лам нар амьдардаг хэдий ч томоохон хурлуудыг хааяа хааяа хурдаг байв.

- Богд хааны ногоон сүм (Богд хааны өвлийн ордон, Шаравпэлжээлин сүм, Эрдэм итгэмжит билгийг хөгжүүлэн бадруулагч сүм, Дээд сүм, Голын ногоон сүм, тө. shes-rab dpal rgyas gling)
- Хайстай лавран (Эрдмийн далай буян чуулган сүм, Богд хааны сэрүүн орд, Хайстай ордон, Хайлаастын сүм ордон (?), Хашаатай лавран)
- Цагаан сүм (Гунгаадэжидлин, Доод сүм, Туулын цагаан сүм, Хотол баясгалант амгалан жаргалангийн сүм, Өвгөн цагаан сүм, Хутагтын цагаан сүм, тө. kun-dga' bde-skyid gling)
- Нароухажидын сүм (Нарухажидын сүм, Пандэлин, Тус амгалангийн сүм, Балданхажидлин, тө. na-ro mkha'-spyod, phan-bde gling, dpal-ldan mkha'-spyod gling)
- Норовлин (Норовлинхай, Эрдэнийн сүм, тө. nor-bu gling-ka)

6. Орос консулын дэнж

Орос худалдаа наймаа дэлгэрсэнээр 1861 онд орос консулын газар нээгдсэн (одоогийн Кино үйлдвэрийн орчим). Оросууд эхлээд Консулын орчим суудаг байжээ. Консулын байшингийн зүүн талд 1869-1870 онд барьсан үнэн алдартаны сүм, Хутагт Тройцийн сүм байгуулагдсан.

- Хутагт Тройцийн сүм (Свято-Тройцийн сүм, Гэгээн Гурвалын сүм, Үнэн алдартны сүм)

7. Маймаачэн, хятад худалдаачдын газар

Манжийн хаанаас хятадууд Монголд ирж худалдаа наймаа хийх ба өр зээл тавихыг хориглосон атал улам олноороо ирцгээж байв.¹⁰ 1778 онд IV богд хятад худалдаачдыг одоогийн Амгаланд (Ботаник) нүүлгэснээр Маймаачэн (Маймаа хот, Наймаа хот, хят. маймайченг) хотын суурь тавигдсан байна. Хятад хот монгол маягын хотоос эрс ялгаатай байсан. Хотын хашаан дотор зөвхөн хятадууд, хашааны гадна

⁹ Пүрэв, 2004, 24.

¹⁰ Рупен, 1957, 162-164.



монголчууд, эрлийзүүд амьдарч байжээ. Хятад сүм дуганууд 1920-оод он хүртэл үйл ажиллагаагаа явуулсан. XX зууны эхээр Амгаланд 14 сүм дуган байжээ. 8 хятад, 6 монгол сүм дуган байв. Маймаачэнгийн хашаан дотор байсан хятад лам нар (хуушаан, хят. he shang) буюу хөх малгайтан лам нар хурал хурдаг байлаа.¹¹ Дашсамданлин дацан нь Хүрээний 10 дацангийн нэг байв. 1937 он хүртэл хурал номоо хурж байсан.

- Хотын хашаан доторхи хятад сүмүүд:
- Амгалангийн Гэсэр сүм (Гуан-ди шүтээн)
- Эрлэг номун хааны сүм
- Дарь Эхийн сүм (тө. sgröl-ma),
- Урчуудын сүм (Мужааны сүм)
- Күнзийн сүм (Күнз богдын сүм)
- Цагаан малгайтын сүм (Лалын сүм)
- Одон сүм

Гаднах хятад сүм

- Эрлэг номун хааны сүм (Эрлэг хааны хойд сүм)
- Гаднах монгол сүмүүд
- Дашсамданлин хурал/дацан (Эрлийзийн сүм, Өлзий даяны сүм, Сандлин дацан (тө. bkra-shis bsam gtan gling grwa-tshang)
- Чойнхорлин сүм (тө. chos-'khor gling)
- Дэжидлин сүм (тө. bde-skyid gling)
- Дагданлин сүм (тө. rtag-brtan gling)
- Пунцоглин сүм (тө. phun-tshogs gling)
- Улааны шашны зоч нарын хурал (Маймаачэн)

8. Дамнуурчин/Дамнуургачин

1877 онд Маймаачэн болон Зүүн хүрээний хооронд, XX зууны эхээр Зүүн хүрээ ба Гандангийн хооронд хятад пүүсүүд нээгдэж эхэлсэн. Хятад худалдаачид бараагаа дамнуураар авчирдаг байснаас Зүүн дамнуурчин, Баруун дамнуурчин хэмээн нэр үүсчээ. Зүүн дамнуурчин хороо (Сэлбийн зүүн эрэгт, Сансар хороолол) XX зууны эхээр Зүүн хүрээний зүүн талд үүсчээ.¹² О.Пүрэвийн бичснээр 1920-оод оны үед Маймаачэнгээс олон пүүс нүүн иржээ.¹³ Үүний хамт 1927 онд Гэсэр сүм нүүж ирсэн. Хүрээ, Гандан хоёрын хооронд Баруун дамнуурчны өмнө хэсэг Хүрээний зах болдог байжээ.¹⁴ Дуган нь:

¹¹ Пүрэв 2004, 104–105. Сэрээтэр 1999, 82.

¹² Пүрэв 2004, 91. Пүрэв 2004, 66.

¹³ Пүрэв 2004, 82.

¹⁴ Позднеев 1971, 64–73.



- Баруун Гэсэр сүм (Гуан-ди шүтээн)

9. Хүрээний захад байсан хийд, сүм дуганууд

Чингэлтэй ууланд Их шавийн 3 томоохон хийд байсан. Нэг нь 4 дацантай олон сүм дугантай, 12 аймагтай Дамбадаржаа хийд, нөгөө нь цамтай Дашчойнхорлин хийд (тө. bkra-shis chos 'khor gling). 3 дахь нь 16 гэлэн, 4 гэцэлтэй Шаддүвлин (тө. bshad sgrub gling) хэмээх даяны газар. Богд хан уулын оргилд Богдын хийд (дуган) буюу Цэцээ гүний хурал жилд нэг удаа Богд хан уулын лус савдагт Монгол улсын сүлд хийморийг сэргээхийн тухайд даатгаж тахьдаг байжээ. Уг уулыг тахихаар лам нар хүрээний Дүнжингаравын сүмээс (тө. dung skyong dkar-po) гардаг байв. Хүрээний захад тэр хавийн хүмүүс мөргөдөг мөргөлийн сүмүүд буюу лус савдагуудыг тахьдаг сүмүүд байсан.

- Дамбадаржаагийн хийд (Дамбадаржаа, Дамбадаржаалин, Шашныг бадруулагч хийд, тө. bstan-pa dar-rgyas gling)
- Дашчойнхорлин хийд (Буян ерөөлт(ийн) сүм, тө. bkra-shis chos-'khor gling)
- Шаддүвлин хийд (Шаддүвлин, Шаддүв гэгээл жанчүвлин, Их шавийн нямба даяаны Шаддүвлингийн хүрээ, Номлол бүтээл баян арвидах Бодь тив (тө. bshad sgrub gling, bshad-sgrub dge 'phel byang-chub gling)
- Дүнжингарвын сүм (Дүнжонгарвын сүм, тө. dung-skyong dkar-po)
- Богдын хийд (дуган) (Цэцээ гүний хурал)
- Рашааны хурал (Лусын жалваа, Лусын жалвуу, Лүмбүмгарав, Лусын сүм, Ловон Жалбын сүм (?), тө. klu-rgyal, klu'i rgyal-po, klu-'bum dkar-po)
- Баянзүрхийн дуган (Хөлний модчны сүм)
- Зүүн салааны хурал
- Баруун салааны хурал
- Санзайн уулын хийд (Санзайдоржийн хурал) (одоогийн Санзай уул)





Дүгнэлт

1937-1938 онд Улаанбаатар хотын сүм хийдүүдийг шатаах, эсвэл нурааж буулгасан. Үлдсэн зарим нь цэргийн хуаран, эмнэлэг, эмийн сан, агуулах, үйлдвэр, цирк, архив, музей гэх мэтээр ашигласан. Хүрээ, хороонд байсан хуучин гэр байшингууд үлдэж хоцорсонгүй. Хуучин хүрээний дээр дурдсан 51 шашны түүхэн газраас хуучин хэвээр нэг ч сүм дуган үлдээгүй. 11 газар одоо байгаагаас өөр өөр зориулалтаар ашиглаж байсан. 40 газарт ямар ч байсан гэх туйр үлдсэнгүй.

Зүүн хүрээний 30 аймгийн дугануудаас гурван дуган л үлджээ (Эх дагинын аймгийн дуган, Вангайн аймаг, Эрхэм тойны аймаг). Мөн Гандантэгчэнлин дуган ба V, VII, VIII Богдын шарилын сүм, Дидонповран, Мигжид Жанрайсэгийн сүм ба Чойжин Ламын сүм, Богд хааны ногоон сүм ба өвлийн орд, Хайстай лавран, Баруун Гэсэр сүм (Гуан-ди шүтээн), Амгалангийн Дарь Эхийн сүм, Дамбадаржаагийн хийдийн хэсэг үлдсэн.

Зургийн тэмдэглэл





Хүрээ 30 аймгаас үлдсэн Вангайн аймаг, Эрхэм тойны аймгийн гэр дуганууд нь одоогийн Зүүн хүрэ Дашичойлин хийдийн Цогчин, Сахиусны дуганууд мөн.



1848 онд барисан Гандантэгчэнлин дуган ба V, VII Богдын шарилын сүмүүд нь одоогийн МБШТөв Гандантэгчэнлийн хийдийн Гандантэгчэнлин, Очирдарын сүмүүд мөн.





Ном зүй

1. Дариймаа, Г., Дурсагдахын буянтай бурхан зураач, УБ, 2003
2. Дүгэрсүрэн, Л., Улаанбаатар хотын түүхээс (2 дахь хэвлэл), УБ, 1999
3. Жүгдэр, Yeke kyiyeu 1913 он (зураг)
4. Pozdneyev, A. M., Mongolia and the Mongols, edited by Krueger, J. R., translated by Shaw, J. R. and Plank, D., Bloomington, Indiana University 1971
5. Пүрэв, О., Монголын улс төрийн төв, УБ, 1994
6. Пүрэв, О., Улаанбаатар 360. УБ, 1999
7. Пүрэв, О., Монгол төрийн голомт, УБ, 2004
8. Ринчен, Б., Монгол ард улсын угсаатны судлал, хэлний шинжлэлийн атлас. УБ, 1979
9. Rupen, R. A., "The City of Urga in the Manchu Period", Studia Altaica, Festschrift for Nicholas Poppe, Wiesbaden, 157-169., 1957
10. Сэрээтэр, Ө., Монголын Их хүрээ, Гандан хийдийн түүхэн бүтэцийн товч 1651-1938. УБ, 1999
11. Teleki, K., Monasteries and Temples of Bogdiin Khuree. Institute of History. Mongolian Academy of Sciences. Ulaanbaatar 2011, 381 pages, ISBN: 978-99962-2-041-8
12. Телеки Кристина, Нийслэл хүрээнд байсан сүм хийдүүд. Лам нарын сэтгүүл 4, УБ, 2010, 86-94.
13. Улаанбаатар. Хотын атлас. Улсын геодези, зураг зүйн газар. УБ, 1990
14. www.archives.gov.mn/index.php?option=com_content&task=view&id=567&Itemid=302&lang=mn
15. www.mongoliantemples.net/en

